

Нутгийн өөрөө удирдах байгууллага

Лекц № 5

Агуулга

- Нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай ойлголт
- Үндсэн чиг үүрэг
- Монгол Улсын нутгийн өөрөө удирдах байгууллага
- НӨУБ-ын сонгууль
- НӨУБ-ын зохион байгуулалт
- Шийдвэр
- Үйл ажиллагаа
- Тулгамдсан асуудлууд

Нутгийн өөрөө удирдах байгууллага

- Чөлөөт, шууд, тэгш, нууц сонгуулийн үр дүнд байгуулагддаг,
- Иргэдийг төлөөлөх, иргэдийн эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй,
- Тухайн нутаг дэвсгэрийн хэмжээний амьдралын асуудлыг иргэдийн эрх ашигт нийцүүлэн хуулийн хүрээнд шийдвэрлэх эрх бүхий

**тухайн нутгийн иргэдийн төлөөллийн
байгууллага**

Төрийн байгууллага уу, эсвэл?

- Нутаг дэвсгэртээ төрийн зарим зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх
- Хүн амаа нэгтгэн зохион байгуулж удирдах
- Орон нутгийн хэмжээний бодлого боловсруулах

гэж үзвэл ТӨРИЙН байгууллагатай төстэй.

Төрийн байгууллага уу, эсвэл?

Гэвч:

- Нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах, төлөөлөх үүрэгтэй
- Төрөөс харьцангуй бие даасан үйл ажиллагаа явуулах эрхтэй

Үндсэн чиг үүрэг

- Нутгийн иргэдийг төлөөлөх
- Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох
- Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэх, хянах

Төлөөлөх чиг үүрэг

- Аливаа төлөөллийн байгууллага нь өөрийн зорилго, үйл ажиллагааныхаа чиглэлээс хамаарч хүн амын (сонгогчдынхоо) тодорхой **нэг** төлөөллийг хангах үүрэгтэйгээр байгуулагддаг.

Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох чиг үүрэг

- Аливаа төлөөллийн байгууллага нь хүлээн зөвшөөрөгдсөн байх, хууль ёсны байх шинжийнхээ дагуу өөрийн үйл ажиллагаа явуулж буй орчинд сонгогчдоо нэгтгэн зохион байгуулах, ерөнхийлөн удирдах үүрэгтэй.

Хянах чиг үүрэг

- Аливаа төлөөллийн байгууллага нь шийдвэрийг нь хэрэгжүүлж, өөрт нь тайлагнаж байх гүйцэтгэх эрх мэдлийн этгээдтэйн хувьд түүнийхээ үйл ажиллагааг нь чиглүүлэх, хяналт тавих учиртай.

Монгол Улсад

- Аймаг, нийслэлд
 - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- Сум, дүүрэгт
 - Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
- Баг, хороонд
 - Иргэдийн Нийтийн Хурал
- Тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт
 - Тэдгээрийн Тэргүүлэгчид

Сонгууль

- Мажоритар систем
 - Олон мандаттай тойрогтой байна
 - Улс төрийн намууд 1 тойрогт мандатын тооноос илүүгүй хүний нэрийг дэвшүүлнэ
 - Тойрогтоо хамгийн олон санал авсан нэр дэвшигчдийг сонгогдсонд тооцно
- Бүрэн эрхийн хугацаа
 - 4 жил байна

Төлөөлөгчдийн тоо

- 50000 хүртэл хүн амтай аймгаас
 - **25** төлөөлөгч
- 50000 – 90000 хүн амтай аймгаас
 - **31** төлөөлөгч
- 90000-аас дээш хүн амтай аймгаас
 - **35** төлөөлөгч

Төлөөлөгчдийн тоо

- Нийслэлээс
 - **45** төлөөлөгч
- Нийслэлийн 20000 хүртэл хүн амтай дүүргээс
 - **21** төлөөлөгч
- Нийслэлийн 20000-80000 хүн амтай дүүргээс
 - **25** төлөөлөгч
- Нийслэлийн 80000-аас дээш хүн амтай дүүргээс
 - **35** төлөөлөгч

Төлөөлөгчдийн тоо

- 2000 хүн амтай сумаас
 - **15** төлөөлөгч
- 2000 – 9000 хүн амтай сумаас
 - **21** төлөөлөгч
- 9000-аас дээш хүн амтай сумаас
 - **25** төлөөлөгч

Хурлын зохион байгуулалтын хэлбэрүүд

- Хуралдаан
- Тэргүүлэгчид
- Хороо
- Намын бүлэг
- Ажлын алба
- Түр хороо

Хуралдаан

- Зохион байгуулалтын үндсэн хэлбэр
- Шийдвэр гаргах үйл явц
- Бүрэн эрхээ, түүний дотор онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэх үе
- Нутаг дэвсгэрийн амьдралын ямар ч асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болно

Тэргүүлэгчид

- Хурлын зохион байгуулалтын хэлбэр
- Хурлын байнгын, тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах үүрэг бүхий бүрэлдэхүүн хэсэг
- Хурлын хуралдааны чөлөө цагт нутгийн өөрөө удирдах байгууллагын үүргийг гүйцэтгэнэ
- Тэргүүлэгчдийн шийдвэр нь Хурлын шийдвэрийн нэгэн адил хүчин төгөлдөр байна
- Гэхдээ Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах асуудлыг шийдвэрлэхгүй

Хороо

- Хурлын зохион байгуулалтын хэлбэр
- Хурлын эрхлэх асуудлын тодорхой чиглэлийг дагнан хариуцна
- Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг боловсруулах, урьдчилан хэлэлцэж дүгнэлт гаргах, эрхлэх асуудлынхаа хүрээнд Хурлын нэрийн өмнөөс хяналт хэрэгжүүлэх үүрэгтэй байх учиртай
- Шийдвэр нь Хурлын шийдвэрийн төсөл, эсвэл түүнд гаргасан санал дүгнэлт, хяналт шалгалтын ажлын дүгнэлт зэрэг хэлбэртэй байна

Намын бүлэг

- Хурлын зохион байгуулалтын хэлбэр
- Хуралдаанаар хэлэлцэх асуудлын хүрээнд улс төрийн намуудын төлөөллийг санал дүгнэлтээ гаргах боломжийг олгож буй
- Хэлэлцэх аливаа асуудалд заавал байр сууриа илэрхийлэх албагүй
- Намын бүлгийн оролцоог нарийвчлан тогтоох шаардлагатай

Ажлын алба

- Хурлын хэвийн үйл ажиллагааг хангахад бүх талын туслалцаа үзүүлэх үүрэгтэй бүтцийн байнгын нэгж
- Удирдлагын ерөнхий чиг үүргийг хэрэгжүүлнэ
- Шаардлагатай үед ЗДТГ-аас туслалцаа авна.

Түр хороо

- Хэлэлцэн шийдвэрлэх гэж буй асуудлыг урьдчилан судлах, тодорхой байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, Хурлын шийдвэрийн хэрэгжилтийг хянан шалгах зэрэг зорилгоор Хурлаас (Тэргүүлэгчдээс) түр ажлын хэсэг (комисс) томилон ажилуулж болно

Төлөөлөгч

- Тухайн ЗЗНДН-ийн иргэдийг төлөөлж, нутаг дэвсгэрийн хэмжээний амьдралын асуудлыг иргэдийн эрх ашигт нийцүүлэн шийдвэрлэхэд оролцох эрх бүхий этгээд
- Хурлын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, иргэдтэй байнгын холбоотой байж, санаа бодлыг нь сонсох, шийдвэрт тусгуулах, Хурлын шийдвэрийг таниулах, сурталчлах үүрэгтэй

Хуралдааны дэг

- Хуралдааны үед үүсэх эрх зүйн харилцааг зохицуулах үндсэн баримт бичиг
- Хуралдааны дэгийг Хурал өөрөө тогтооно
- Анхдугаар хуралдааны дэгийг ялган тогтоож болно

Хуралдааны дэгээр зохицуулах харилцаа

- Хуралдааныг нээх, хаах
- Хуралдааныг даргалах
- Хуралдааны дотоод журам
- Хуралдааны явцын тэмдэглэл хөтлөх
- Хуралдааны бичиг баримт боловсруулах
- Асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргах
- Санал гаргах, хураах, тоолох
- Шийдвэрийг ёсчлох

ИТХ-ын шийдвэр

- ИТХ-ын тогтоол
- ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол
- ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан дүрэм, журам, уриалга, хөтөлбөр, зөвлөмж, төлөвлөгөө, заавар, төсөв, гэрээ, бусад эрхийн акт

Шийдвэр гаргах үйл явц



Үйл ажиллагааны онцлог

- Байнгын бус ажиллагаатай
- Хамтын хариуцлага хүлээнэ
- Орон нутгийн хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлно
- Засаг даргын үйл ажиллагааг чиглүүлж удирдана, хяналт тавина
- Орон нутгийн төсвийг баталж, гүйцэтгэлд нь хяналт тавина

Үйл ажиллагааны онцлог

- Нутгийн иргэдийн эрх ашгийг төрийн өмнө төлөөлнө. Эрх ашгийг нь хамгаалах, илэрхийлэх албан ёсны, цорын ганц, эрх бүхий этгээд байна
- Иргэдийн өөрсдийнх нь оролцоотойгоор орон нутгийг удирдах албан ёсны удирдлага байна
- Орон нутгийн хэмжээний шийдвэр гаргахад иргэдийг оролцуулах үндсэн хэлбэр байна

Эрхээ хамгаалах нь

- Үндсэн хуулиар (?)
- Захиргааны хэргийн шүүхээр (?)
- Төрийн бус байгууллагаар дамжуулан (?)
- УИХ-аар дамжуулан (?)
- Засгийн газраар дамжуулан (?)

Эвлэлдэн нэгдэх (?)

- Хэрэгцээ бий юу?
 - Яах гэж?
- Эрх ашгаа хамгаалах гэж ...
- Харилцан суралцах гэж ...
- Хөгжих гэж ...

Асуудлууд

- Иргэдийн оролцоо сул байна
 - Тэд оролцох эрхтэйгээ мэддэггүй, оролцох учраа олдоггүй, мэдсэн ч хүсдэггүй байх нь элбэг байна.
 - Тэднийг оролцуулах талаар НӨУБ санаачлагагүй ажиллаж байна.
 - Төр, төрийн байгууллагад итгэх итгэл суларсан
- НӨУБ-ын үйл ажиллагааны мэдээлэл хомс, хүртээмж муу байна.
 - НӨУБ өөрийн үйл ажиллагаагаа нээлттэй болгоогүй, сурталчилдаггүй.
 - Иргэдтэй холбоотой ажилладаггүй, иргэдийг сонсдоггүй хэвээр байна.

Асуудлууд

- НӨУБ-ын үйл ажиллагаа жигдрээгүй байна.
 - Бие дааж ажиллах эвээ олоогүй, зохион байгуулалт сул, залгамж холбоо байхгүй
 - Нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх бодлого тогтоох, "хөгжлийг авч явах" учраа олоогүй
 - НӨУБ ба НЗБ-ын харилцаа тогтворжоогүй
 - Намуудын оролцоо хэт их, үүнээс хамаарч орон нутгийн эрх ашиг хохирдог

Асуудлууд

- Төрөөс НӨУЁ-ыг төлөвшүүлэх нэгдсэн бодлого дутагдаж байгаа
 - Төрөөс НӨУЁ-ыг дэмжиж байгаа идэвхтэй байр суурь үндсэндээ үгүй
 - УХХ хэрэгжиж дууссанаас хойш нэгдсэн бодлогогүй болсон
 - Шинээр гарч байгаа хууль, бусад зохицуулалт нь нэг салбарын бодлогыг хэт дагнасан, эргээд төвлөрүүлж байна
 - ТЗБ-уудын зүгээс НӨУЁ-д харш үйлдэл хийх, үгүйсгэх, НӨУБ-ын үйл ажиллагаанд хутгалдан орох зэрэг нь элбэгшсэн
- Төрийн захиргааны шинэчлэл үндсэндээ зогссон

Боловсронгуй болгох талаар

- Орон нутагт эрх мэдэл шилжүүлэх
 - Татварын эрх
 - Төсвийн эрх
- Төв, орон нутгийн эрх мэдлийн заагийг тогтоох
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг өөрчлөх
 - Томсгох, гэхдээ ...

Унших даалгавар

- Л.Золзаяа, Л.Лувсанжамц: Монголын нутгийн удирдлагын өнөөгийн төлөв байдлын үнэлгээ УБ.,2000
- Я.Бямбаяр. Нутгийн өөрөө удирдах ёсны хөгжлийн хандлага, хэрэгцээ. ХБНГУ, Монголын хамтарсан “Хүчирхэг орон нутаг – Хүчирхэг төр” бага хуралд тавьсан илтгэл. Улаанбаатар. 2006